

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”
Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234741

ХОРЧИНЫ “БОДЬ ГАЛАВ ХААН” ТУУЛИЙН СУДАЛГААНЫ ТОЙМ

М.Хосбаяр

Товчлол. Монгол туульсын нэг төв болох Хорчины туульсын дундаас хорин дөрвөн бүлэгт (арван найман том бүлэг, зургаан салаа бүлэг) Галавын үлгэр нь агуулга, хэлбэрийн хувьд нэлээд онцгой өвөрмөц бүтэц, дүр, дүрслэхүүнтэй билээ. Энэхүү арван найман бүлэг туулийн эхний бүлэг нь “Бодь галав хаан” тууль бөгөөд анхны галав, түрүү галав ч гэж нэрлэдэг. Анхны галав болох “Бодь галав хаан” туульсын дараагийн бүлэг тууль нь “Алтан галав хаан”, гуравдугаар галав нь “Төгсцогт баатар хаан”, дөрөвдүгээр галав “Алтан гэрэлт аварга чулуун баатар”... арван долоодугаар галав “Зөн билигт баатар”, арван наймдугаар галав “Хөх бух” зэрэг болно. Хорчинчууд эдгээр туульсаа “Арван найман галавын үлгэр” буюу “Арван найман мангасын үлгэр” хэмээн хоёр янзаар нэрлэж иржээ. Тэдгээр туульсаас “Бодь галав хаан” гэх эхний хоёр туульсын өгүүлэмж нь ертөнц дэлхийн үүтгэлийн тухай өгүүлсэн болохоор галавын үлгэр гэжээ. “Бодь галав хаан” туульд Бодь галав хаан, Шилин галзуу баатартай хамт Эвэрт мангастай тулалдан ялсан тухай баатарлаг үйл хэргийг магтан хайлдаг тул мангасын үлгэр эсвэл мангасыг дарсан үлгэр хэмээн нэрлэдэг. Бид энэ өгүүлэлдээ хорчинд уламжлагдан, дэлгэрч ирсэн анхны галав гэгдэх “Бодь галав хаан” туулийг судлаачид хэрхэн эмхэтгэн цуглуулж, судлан шинжилж ирснийг товчилж, эмхэлж, бүртгэх ба судлаачдын үнэлэлт дүгнэлтийн үнэ цэнэ, үнэлэмжийг тодруулах үүднээс энэхүү өгүүллийг бичив.

Түлхүүр үг: Хорчинууд, “Бодь галав хаан”, Галавын үлгэр, Мангасын үлгэр, домог, тууль

Судалгааны тойм

Нэг. Хорчины “Галавын үлгэр” буюу “Мангасын үлгэр”-ийг эмхэтгэн цуглуулсан нь

БНХАУ-ын нутаг дэвсгэр дэх баатарлаг туулийн гурван нутаг нь Шинжааны Ойрад, Хөлөнбуйрын Бараг Буриад, Хорчины Жарууд болно. Түүний дотроо Хорчин нутгийн тууль “Бодь галав хаан” нь Хорчины туульсын дунд голлох томоохон туульс юм.

Хамгийн анх XVIII зууны эхэн үед буюу 1716 онд Бээжин барын “Гэсэр”-ийг хэвлэснээр монгол туулийн судлал эхэлж, үүний дараа монгол туулийг эмхэтгэн судлах ажлууд хөгжсөөр иржээ. Энэ ч утгаараа “Гэсэрийн тууж” нь утга агуулгын хувьд Хорчин тууль хийгээд Галавын үлгэртэй нягт уялдаа холбоотой.

Хорчин туульсын аман сурвалжийг анх цуглуулах ажил 1958 оноос эхэлж, Бээжин барын “Гэсэр”-ийг анх хэвлэн нийтэлснээс хойш 244 жилийн дараа буюу 1960 онд анх монгол хэл утга зохиолыг судлах газрын дотоод хэвлэлээр

“Баатруудын тууль”¹ гэх түүврийг эмхэтгэн гаргаж байжээ. Тус түүвэрт Жаруудын хуурч Пажэйн хэлсэн “Мангасыг дарсан үлгэр” хэмээх туулийг Оргил тэмдэглэж, “Алтан гэрэлт хааны Аварга чулуун баатар” туулийг Доронга тэмдэглэн хэвлүүлжээ. Мөн “Догшин хар баатар” туулийг Эрдэнэтогтох тэмдэглэж, “Монгол үндэстний утга зохиолын материалын эмхэтгэл”-ийн гуравдугаар дэвтэр² -т хэвлүүлжээ.

1962 онд Жаруудын цоорч Чулууны хэлсэн 5000 мөртэй “Асар цагаан хайчин” туулийг Ф.Төгс эмхэтгэн найруулж, 6000 мөртэй “Асар цагаан хайчин” гэх тус нэрээр нь хэвлүүлэв. 1965 онд Жарууд нутгийн алдарт хуурч Муу-охины “Эрийн дээд Арьяахүү” туулийг Э.Бадрах тэмдэглэн авч, Цоорч Чулуу, Насантөмөр нарын хайлсан “Асар цагаан хайчин баатар” туулийг Бадам эмхэтгэн, цоорч Балжиннямын хайлсан “Дөшбалт баатар” туулийг Доронга, Соёлт нар эмхэтгэн “Монгол үндэстний утга зохиолын эмхэтгэл” -ийн дөрөвдүгээр дэвтэр -т хэвлүүлжээ.

Монгол аман зохиолын өвөрмөц уламжлал болох “Галвын үлгэр” буюу “Мангасын үлгэр” -ийг эмхэтгэн цуглуулж, судалгааны эргэлтэд оруулсан нь 1970 -аад оны дунд үед хамаарна. Үүнд, Б.Рифтин, С.Ю.Неклюдов, С.Дулам, В.Хайссиг, Ф.Файт, Дулаан, Бүтээлт, Хасбаатар, Түн Жан Үн нарын судлаачдыг голлон нэрлэж болно.

Мөн түүнчлэн 1974 -1976 оны хооронд Б.Рифтин, С.Ю.Неклюдов Монгол улсын Дундговь аймгийн хоёр хуурчаас 1500 мөртэй “Гэсэр ба Гялбан шарын дайн”, 600 мөртэй “Гэсэр Гардан мангасыг номхотгосон”, 700 мөртэй “Гялбан шарын мэндэлсэн”, 70 мөртэй “Рогмогуагийн гуниглал” гэсэн дөрвөн бүлэгт мангасын үлгэрийг тэмдэглэн авсан бол 1976 онд С.Дулам Хорчины Сүргийн хошуунаас Улаанбаатар хотод 1940 оод оны үед нүүж ирсэн Баярын Чунраа хэмээх Хорчин өвгөнөөс “Галавын үлгэр” -ийг тэмдэглэн авсан байна. С.Дулам өөрийн тэмдэглэн авсан Галавын үлгэрээ 1982 онд орос хэлэнд орчуулж³, 1983 онд тэрээр эрдэм шинжилгээний галиг үсгээр буулган, судалгааны удиртгал, тайлбар бичиж, Я.Вацектай хамтран, Прагийн их сургуулийн Дорно дахины судлалын цувралаар “A Mongolian Mythological text”⁴ (Монгол домог зүйн бичвэр) тусгай боть болгон англи хэлээр хэвлүүлжээ. Хорчины үлгэрийг танилцуулсан энэ номын тухайд В.Э.Раднаев, С.Ю.Неклюдов, В.Хайссиг, Дулаан, Дулаан нар шүүмж бичжээ.

Хоёр. “Бодь галав хаан” туулийг эмхэтгэн цуглуулсан нь

Хорчин туульс хийгээд галвын үлгэрийн уламжлалын дотроос бидний сонгон судалж буй “Бодь галав хаан” туулийг эмхэтгэн цуглуулсан тухайд:

¹ Doronga. (1960). Bayaturliq tuuli. [Баатарлаг тууль] Kökeqota : Öbür Mongγol-un arad-un keblel-ün qoriy-a 136-171,1-47.

² Mongγol ündüsüten-ü udq-a jökiyal-un material-un emkidkel, yurbaduyar debter. [Монгол үндэстний утга зохиолын материалын эмхэтгэл, гуравдугаар дэвтэр] Kökeqota: Öbür Mongγol-un kele jökiyal sudulqu yajar.

³ Дулам,С. (1982). Образы Монгольской мифологии и литературная традиция.УБ:МУИС-ийн хэвлэл.150-217.

⁴ Дулам,С. “A Mongolian Mythological text”. 2013 онд Б.Чунраа гуайн фото зураг, товч намтрыг нэмж, тус номоо Монгол улсад дахин хэвлүүлжээ.

1980 -аад оны сүүл үеэс эхэлсэн байна. Тус туулийг сурвалжлан цуглуулах ажилд В.Хайссиг, Сампилноров, Түн Жан Үн, Бүтээлт, Буянтогтох нарын хүмүүс голлон ажиллажээ.

1988 онд В.Хайссиг Хорчины Морин сүмээр нутагтай Сэрэн гуайн амаар аялгуулан хэлсэн “Бодь галав хаан”, “Алтан галав хаан” хэмээх хоёр туулийг тэмдэглэн авсан ба 1988 онд “Алтан галав хаан”⁵ хэмээх нэрээр эмхэтгэн хэвлүүлсэн. Даруй 1990 онд Сампилноров мөн Сэрэн гуайн хайлсан “Бодь галав хаан” туулийг тэмдэглэж, “Бодь галав хаан”⁶ гэх эмхэтгэлийг хэвлүүлжээ.

2006 онд Бүтээлт Бүрэнцуглаа туульчийн хайлсан “Бодь галав хаан” туулийг хялгасан утсанд шингээн авч, дараа нь тус “Бодь галав хаан” туулийг Цэнгэл эмхэтгэн найруулж, Түшээт хошууны соёлын товчооноос хэрэгжүүлсэн бодисын бус соёлын өвийн төслийн хүрээнд 2021 онд “Хорчин цоор тууль”⁷ хэмээх нэрээр хэвлүүлжээ.

2019-2022 онд Буянтогтох Жалсан хуурчийн хайлсан “Бодь галав хаан” зэрэг хорчины 18 галавын үлгэрийг видео бичлэгт шингээснээ монгол бичигт буулган, Галвын үлгэрийн баялаг хөмрөгийг бүрдүүлж өгчээ.

Гурав. Хорчины “Галавын үлгэр” буюу “Мангасын үлгэр” -ийг судалсан нь

1979 онд В.Хайссиг “Монгол тууль – 8” хэмээх эмхэтгэлдээ Пажэйн хайлсан “Мангасыг дарсан үлгэр”, “Алтангэрэлт хааны Аварга чулуун баатар” болон “Гэсэр баатар” -ыг галиглан, Герман хэлээр орчуулсан бөгөөд Пажэйн хэлсэн мангасын үлгэр, “Гэсэр баатар” -ыг монгол тууль судлалын онолын аргаар шинжлэн судалсан юм. 1979 онд “Рвайн Вастфэлен шинжлэх ухааны академийн илтгэл” гэх цувралд туулийн баатрын аялал, бөөгийн үйл ажиллагааны хооронд ойрхон зэрэгцэл байгаа ба Буддын шашны тухай төсөөлөл мангасын дүрд нөлөөлөн байгааг тэмдэглэн, энэ нь төв Азийн 2000 жилийн өмнө баатарлаг туулийн гарал үүсэлтэй Монгол, Түрэг, Төвөдийн тууль эртний үүсэлтэй болохыг харуулж байна гэжээ. (Хайссиг, 1979:10-14) В.Хайссигийн “Монгол баатарлаг туулийн хүүрнэх материал” гэх хоёр боть томоохон бүтээлд монгол эл орноор тархаж байгаа төлөөлөгч чанартай 47 туулийн хороонд гүнзгий харилцуулсан судалгаа нийж, эдгээр туулийн хоорондох харилцаа холбооны талд задлалт хийсэн юм. Үүний үр дүнд “Галавын үлгэр”, “Асар цагаан хайчин баатар”, “Дөшбалт баатар”, “Асар цагаан хайчин”, “Эрийн сайн Арьяахүү”, “Марлангийн тууж” зэрэг Мангасын үлгэрийн бүтээлд суурилж, түүний бүтэц, өгүүлэмжид судалгаа хийх ажлууд өрнөсөн юм. Мангасын үлгэр нь уламжлалт монгол баатарлаг туулийн хэв намба байхыг гэрчилсэн бөгөөд Хорчин туулийн харьцуулсан судалгаа хийх үндэс суурийг тавьсан хэмээн судлаачид дүгнэсэн байна.

⁵ Qaissig, W. Feyt, F. Nim-a. (1988). Altan ʻalba qaʻan. [Алтан галав хаан] Kökeqota: Öbür Mongγol-un arad-un keblel-ün qoriy-a

⁶ Sawanpilnorbu, Čoyijikawa, Čimbey, T (1990). Bodi ʻalba qaʻan. [Бодь галав хаан] Kökeqota: Ündüsüten-ü keblel-ün qoriy-a.

⁷ Čenggel. (2021). Qorčın čoyur tuuli. Degedü. [Хорчин цоор тууль, дээд] Kökeqota: Öbür Mongγol-un yeke surγaγuli-yin keblel-ün qoriy-a.

1984 онд С.Ю.Неклюдов “Монголын баатарлаг тууль” номдоо Галавын үлгэрийн баатруудын нэг болох мангасын охин Галвин Сөөрийн дүрийг Гэсэрийн туужийн Хорчины Жаруудын хувилбарын мангасын охин Гялбан шартай харьцуулан судалсан байна. Мөн тэрээр 1999 онд Галавын үлгэр болон зүүн монголын үлгэрлэг туулийг зэрэгцүүлж судлаад, “Монгол туульсын баатар зорьсон газраа хүрч ирээд сүйт бүсгүйн аав болон ах нь охиныг өгөхгүй гэхэд тулалдаж дийлээд, охиныг булаан авч буцдаг бол Галавын үлгэрт мангасын хүүд амласан умард замбалын орны гүнжийг авч харьж байна. Мангасын орон луу аянд гарсан баатруудын өмнөөс мангасын үзэшгүй муухай охин тосон ирж байгаа өгүүлэмж бас энэ Галавын үлгэрт Алвин Сөөрий гэж шулмын дүрээр мөн дүрслэгдэж байна. Өгүүлэмжийн энэ их олон төсөөтэй үйл явдлууд юуг харуулж байна гэхээр энэ Галавын үлгэр гэдэг тууль нь зүүн монголын уламжлалаас хожуу хөвөрч гарсан, бусад үлгэр туультай нэгэн эх сурвалжтай юм гэдгийг харуулаад байна” (С.Ю.Неклюдов, 1999, 101) гэж дүгнэжээ.

Хорчины Галавын үлгэр буюу Мангасын үлгэрийн судалгаа нь БНХАУ -д нэлээд хожуу үед буюу XX зууны наяд оны дунд үеэс эхэлсэн байна. Хорчин туулийг судалсан судлаачдаас дурдвал Уранчимэг, Дулаан, Зоригт, Ү. Хурц, Зандан, Бай Жин Сүе, Гэрэлтуяа нар, Хорчин туулийн дүрийн судалгаанд Хүрэлшаа, Загар, Г.Буянбат, Хөгжихү, Цэцэн, Хөххас, Эрдэнгоо, Б.Гэрэлт, Гүй Лан, Ургамал, Төгсбаяр, Дулаанцэцэг, Хөгжихү нар бол Хорчин туулийн гоо зүй, соёл зүй, зан үйлийн судалгааны талд Б.Бүрэнбэх, Нима, Г.Намжил, Сампилноров, Жү юэ, Ли Мэй, Соргог, Цэлмэг нарын судлаачдыг дурдаж болно. Хорчин туулийн ая аялгууны талаас Бүтээлт, Түн Жан Үн, Зоригт, Цэнгэлт зэрэг хүмүүс судалгаа хийж байгаа юм. Хорчин туулийн мангасын сүнс орших орон зайн талаас Д.Таяа, бүтэц судлалын талаас Хай Рүй бөгөөд Пажэй судлаач Ургамал, Ү. Шугараа нарыг дурдаж болно.

1980 -аад оны сүүл үеэс Уранчимэг хорчин туулийн агуулгыг судалж, “Хорчин туулийн тухай өгүүлэх нь” (1988), “Хорчин туулийн онцлог” (1989), “Монгол баатрын туулийн түүхэн барилдлага” (1990), “Хорчин тууль дахь хүн хийгээд байгаль” (1997) зэрэг өгүүлэл дэвшүүлэн, “Хорчин тууль бол монгол баатрын туулийн хорчин дахь хувилбар мөн” гэж үзсэн ба зүүн монгол буюу хорчин нутгийн хагас нүүдэлчин, хагас тариачин орны түүх соёлтой уялдуулж Хорчин туулийг шинжилжээ.

1985 онд Ү. Шугараа Хорчин хуурч Пажэйн тухай “Пажэйг өгүүлэх нь”⁸ (Шугараа,1985) хэмээх эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж, хуурч Пажэйн “Мангасыг дарсан үлгэр”, “Алтан гэрэлт хааны аварга чулуун баатар” зэрэг хоёр үлгэрийг танилцуулж утга агуулгын задлалтыг хийжээ.

1998 онд Нима “Зүүн монголын мангасын үлгэрийн тухай”⁹ (Нима,1998) өгүүлэлдээ мангасын үлгэр хэлэх хэлбэр хэмээх бүлэгтээ “Бодь галав хаан” ба “Алтан галав хаан”-ы тухай дурдан өгүүлжээ. “Бодь галав хаан” ба “Алтан галав хаан” туулийг хайлахад хэдэн ая хэрэглэдэг, ямар аяыг аль хэсэгт хэрэглэдэг

⁸ Šügara, Ü. (1985). Pajayı-yı ögülekü ni. [Пажэйг өгүүлэх нь] Kökeqota: Öbür Mongyol-un arad-un keblel-ün qoriy-a.

⁹ Nim-a. (1988). Jëgün mongyol-un mangyus-un üliger-ün tuqai. [Зүүн монголын мангасын үлгэрийн тухай] Kökeqota: Öbür Mongyol-un bayči-ün yeke suryauli-yin erdem sinjilegen-u sedkül.

тухай тооцон өгүүлсэн нь туулийн аман хувилбар түүний ая данг ямар байх тухай шинжилгээ судалгааны ажлыг мөн адил өрнүүлж чадсан байна.

2003 онд Дулаан “Мангасын үлгэрийн онол зүй”¹⁰ хэмээх нэг сэдэвт бүтээлдээ Хорчин туулийн эмхэтгэн цуглуулж, судлан шинжилсэн байдал, Халх-Барга тууль дахь Мангасын үлгэрийн харилцаа холбооны тухай, Энэтхэг туулийн Хорчин туульд үзүүлсэн нөлөө тусгал гэх зэрэг талаас харьцуулсан судалгаа хийсэн нь домог зүйн онол ёсоор хамаг анх эхэн үе болон хожим хөгжсөн туульс хоёрын дүрүүдийн уялдаа холбоо, утга агуулга өгүүлэмжийн судлалыг харьцуулсан зүйл нэлээд ажиглагдана. Мөн соёлын шилжилтийн зүйлээс шалтгаалан Энэтхэгийн туулийн нөлөө Хорчин туульд яаж хэрхэн нөлөөлсөн хийгээд үг хэллэгийн судалгааг хийсэн нь мөн л харьцуулсан тууль судлалд чухал нөлөөг үзүүлж чадсан юм. Эдгээр судалгаа нь “Бодь галав хаан”, “Алтан галав хаан” туульс зэрэг Хорчин туулийг судлаад “Хорчин тууль ‘Бодь галав хаан’ туулийг хувирмал тууль мөн” гэсэн дүгнэлт хийсэн нь тус туулийн хувилбарт маягаар Хорчин нутагт тархсаныг нотлон заасан хэрэг болжээ.

2006 онд Сампилноров “Хорчин монголчуудын (мангас) хайлах заншил” (Сампилноров, 2006) өгүүлэлдээ “Хэрэв Мангасын үлгэр хайлсан байдалд заавал нэг Галавыг бартал хэлэх хэрэгтэй гэнэ. Хагас дутуугаар зогсвол сонсож байгаа хүмүүс ба тууль хайлж байгаа туульчидад ашиггүй зүйл авчирдаг гэж үздэг” гэж тууль хайлах эртний уламжлал, дэг ёс заншил сэтгэлгээний үнэт зүйлсийг мөн адил дурдаж өгсөн нь тус туулийн ямар эртний хэв загварыг хадгалсан тууль болохыг тодруулж өгчээ.

2007 онд Г.Намжил “Хорчин туулийн гоо зүйн судлал” (Намжил, 2007) өгүүлэлдээ муухай гоо, шаглахуй гоо, сэбүүн гоо гэх гурван төрөл хуваан Хорчин туулийг гоо зүйн талаар судалсан нь сонирхолтой өгүүлэл болсон юм.

2008 онд Зоригт “Хорчин монголчуудын хуурын үлгэр ба хүүрнэл дууны харьцуулал”¹¹ (照日格图, 2008) өгүүлэлдээ Хорчин монголчуудын хуурын үлгэрийн буй болсон цаг хугацаа, хөгжилтийн талаар өгүүлсэн байна. Өгүүллэгийн гол хэсэгтээ: “Баатарлаг тууль нь Хорчин ардын дуунд хэрхэн нөлөөлсөн, хуурын үлгэр нь хүүрнэл дуунд ямар нөлөө тусгал” болсон талаар задлан шинжилжээ.

2009 онд Бай Жин Сүе “Шинжаан ойрад хийгээд Хорчин туульс дахь мангасын дүрийн харьцуулсан судлал”¹² (Бай Жин Сүе, 2009) өгүүлэлдээ хоёр газрын мангасын үйл хөдлөл, үг яриа, гадаад дүр төрх зэрэг талаас судалгаа хийж, ойрад туулийн мангас нь их төлөв зөв талын баатартай адилавар сайн эрийн дүрээр илэрвэл, харин Хорчин тууль дахь мангас нь шулам дүрээр илэрдэг нь илүү гэсэн дүгнэлтэд хүрчээ. Тэр бээр бас аль газар орны мангас нь харилцан

¹⁰ Sen Gan Lün. (2003). Mangyus-un üliger-ün onul. [Мангасын үлгэрийн онол] Begejing: Begejing-ün bayči-yin yeke surγayuli-yin keblel-ün qoriy-a.

¹¹ Zhaorigetu. (2008.03). Ke er qin meng gu zu shuo chang yi shu – hu ren wu li ge er wu xu shi min ge bi jiao. [Хорчин монголчуудын хайлах урлаг - хуурын үлгэр дэх хүүрнэл бус ардын дууны харьцуулалт] Tian jin: Tian jinshi fan da xue yan jiu sheng xue wei lun wen.

¹² Bai Jin Süye. (2009.06). Sinjiyang Oyirad tuuli kiged qorčin tuuli daki mangyus-un dūri-yin qarīcaγuluγsan sudulul. [Шинжаан ойрад тууль хийгээд хорчин тууль дахь мангасын дүрийн харьцуулсан судлал] Kökeqota: Öbür Mongγol-un yeke surγayuli-yin magistriin jerge γorilaysan ögüel.

нийтлэг талтай боловч мангас болгоныг адилхан гэж үзэж болохгүй, аль газар орон, овог ястны тууль дахь мангас нь өвөрмөц онцлогтой гэдгийг сануулан хэлжээ.

2012 онд Зандан “Хорчин тууль дахь мангас хийгээд аман үлгэр дэх муусын харьцуулал”¹³ (Зандан, 2012) хэмээх өгүүлэлдээ мангас ба муусын үүсэл гарал ба хүйс, гадар дүр, оршин амьдрах орон зай болон хөдлөл дөрвөн талаас шинжлэн судалжээ.

2013 онд Ли Мэй “Зан үйлийн хараанаас Хорчин туулийг шинжлэх нь”¹⁴ (Ли Мэй, 2013) гэх өгүүлэлдээ Хорчин туульд тусгагдсан аж ахуйн зан үйл, нийгмийн зан үйл, шүтлэг бишрэлийн зан үйл гэдэг гурван том бүлгээр бичиж, Хорчин туулийг уран зохиолын талаас биш харин зан үйлийн талаас нь судлах хэрэгтэй гэж өгүүлжээ.

Мандах 2014 онд хэвлүүлсэн судалгааны түүвэртээ “Жалсан хуурчийн хэлсэн Мангасын үлгэрийн тухай”¹⁵ өгүүлэлдээ “Эл төрлийн шидэт үлгэрийн агуулга нь арван найман Галавын үлгэрийг нөлөөлсөн бөгөөд Жалсан хуурчийн хайлсан арван найман Галавын үлгэр нь туулийн хэлбэртэй шидэт үлгэр болжээ” гэсэн санааг дэвшүүлжээ. Мөн онд Жү Шүан Ши “Хорчин туулийн өвөрмөц шинжийн тухай өгүүлэх нь”¹⁶ хэмээх өгүүлэл бичиж, Хорчин туулийн агуулга хэлбэрийн өвөрмөц шинж, орон нутгийн өвөрмөц шинж ба дүрийн өвөрмөц шинж гэх гурван талаар шинжлэн өгүүлсэн байна.

2017 онд судлаач Ургамал “Пажэйн Гэсэр хийгээд Хорчин Мангасын үлгэрийн уран дүрийн харьцуулсан судлал”¹⁷ өгүүлэлдээ монгол туульсын дүрийн судлалын тогтсон мотив болох: Пажэйн Гэсэр ба Хорчин Мангасын үлгэрийн зөв талын баатрын дүр, Пажэйн Гэсэр ба Хорчин Мангасын үлгэрийн эсрэг талийн баатрын дүр, Пажэйн Гэсэр ба Хорчин Мангасын үлгэрийн хөлөг морины дүрийн харьцуулал” гэсэн гурван зүйлээр дамжуулан Пажэйн Гэсэрийн дүрийн судлалыг хийжээ. “Тэрээр нэгд дээрх хоёр туулийн гол баатрын дүр бол бүр сахиулсны нэгдмэл шинжийг бүрэлдүүлсэн дүр болно гэжээ” (Ургамал, 2017:52) Түүний тус судалгааны өгүүллийн гол санаа нь мангасын дүрүүдийн харьцуулсан судлал, байгалийн хүч, хөлөг морины дүрүүдийг голчлон судалсан байдаг.

2020 онд Ли Жан Шин “Хорчин туулийг хайлах цоор жич цоордох арга барилын судалгаа- Бүрэнцуглаа цоорчийн хайлсан Асар цагаан хайчин жишээн

¹³ Čandan. (2012.02). Qorčin tuuli daki mangγus kiged aman üliger dek mangγus-un qaričayulul. [Хорчин тууль дахь мангас хийгээд аман үлгэр дэх мангасын харьцуулал] Tungliyao: Öbür Mongγol-un ündüsüten-u yeke surγayuli-yin erdem sinjilegen-u sedkül.

¹⁴ Li Meyi. (2013). ĵang üile-iin qarayān-ača qorčin tuuli-iy sinjilekü ni. [Зан үйлийн хараанаас хорчин туулийг шинжлэх нь] Kökeqota: Öbür Mongγol-un bayči-yin yeke surγayuli-yin magistriin jerge yorilaysan ögülel.

¹⁵ Manduqu. (2014). Mandaqu jokiyaal-un tegübüri. [Мандах зохиолын түүвэр] nigedüger boti. Kökeqota: arad-un aman jokiyaal-un onul, Öbür Mongγol-un arad soyul-un keblel-ün qoriy-a.

¹⁶ jü Süan Si. (2014.02). Qorčin tuuli-yin öbermiče sinji-yin tuqai ögülekü ni. [Хорчин туулийн өвөрмөц шинжийн тухай өгүүлэх нь] Kökeqota: Dumdadu ulus-un mongγol sudulul,52.

¹⁷ Uryumal. (2017.06). Pazai Geser kiged qorčin mangγus-un üliger-ün düri-ün qaričayulul. [Пазэй Гэсэр хийгээд хорчин мангасын үлгэрийн дүрийн харьцуулал] Barayun qoid ündüsüten-u yeke surγayuli-yin magistriin jerge yorilaysan ögülel.

дээр¹⁸” хэмээх магистрын зэрэг горилсон өгүүлэл бичиж, Хорчин баатарлаг туулийн ая аялгуу, цоор, цоордох арга, тууль хайлх тухай зэрэг дөрвөн талаас нь судалгаагаа хийсэн байна.

Монголоос Хорчинчуудын монголын баатарлаг туульс хийгээд Галавын үлгэрийн сонирхон судалсан цөөн юм. 1983 онд С.Дулам Хорчины энэхүү аман уламжлалын жишээг судалгааны эргэлтэд оруулснаас хойш 2019 онд Г.Нандинбилиг БНХАУ-ын Өвөр монголын өөртөө засах орны Жирэм аймгийн Тунляо хотод зохион байгуулагдсан “Хуурын үлгэр” сэдэвт ОУЭШ-ний хуралд хэлэлцүүлсэн илтгэлдээ Б.Чунраа өвгөний ярьсан Галавын үлгэрийн уламжлалын дүр, өгүүлэмжийг нарийвчлан судлаад, төрөл зүйлийн тухайд “Мангас махчны домог зүй” гэж үзсэн ялгаатай саналыг дэвшүүлсэн байна. Мөн тэр бээр 2020 онд МУИС-ийн “Монгол судлал” сэтгүүлд дэх “Хорчины Галавын үлгэр дэх домог зүйн дүр, өгүүлэмж” гэх гарчигтай өгүүлэлд: хорчины галавын үлгэрийг өвлөн тээгч, үлгэрч, цоорч С.Жалсан гуайтай 2019 онд Тунляо хотод уулзан сурвалжилсан хээрийн судалгаандаа тулгуурлан судлаад, “Галавын үлгэр” хэмээх энэ туурвилд сүлэлдэн байгаа олон янзын хам сэдэв, дүр, өгүүлэмжүүд нь төрөл зүйлийг тодорхой тогтооход бэрхшээл үүсгэдэг ч дүрийн онолын үүднээс шинжилбэл хүний хүчин чадлыг бус, эсрэгээр дээд тэнгэр нарын шийдвэр, хүч, оролцоог тунхаглан байгаа нь тус бүтээлийн домог зүйн шинжийг баталж байна”¹⁹ хэмээн тус туулийн баатрууд болбоос энэ замбуулин хорвоо дээрх хар толгойтой энгийн хүмүүс бус бүр сахиус бурхдын тухай өгүүлэмжээс бүрдсэн, даруй тус туулийн доторх жижиг жижиг мотивууд нь өөр хоорондоо хэрхэн сүлэлдэн оршиж байгаа зэргийг тодруулж өгсөн байна.

Дөрөв. “Бодь галав хаан” туулийг судалсан нь

“Бодь галав хаан” туулийн талаарх тусгай судалгаа нь 2000 -аад оны үеэс эхэлсэн ч сүүлийн жилүүдэд эрчимжиж байна. Үүнд, Яан Юуй Сэн /Бүтээлт/, Түн Жан Үн, Ү. Хурц, Ли Жан Шин, Ин Жэ, Соргог, Мандахүү нарын магистрантуудын магистрын зэрэг горилж бичсэн судалгааны ажлууд нэлээд эрчимжсэн байна. Тухайлбал 2007 онд Түн Жан Үн “Бүрэнцуглаагийн хайлсан ‘Бодь галав хаан’ туулийн дууны талаар судалгаа хийх нь” хэмээх сэдэв, 2009 онд Ү. Хурц “Ардын урлагч. М.Бүрэнцуглаагийн “Бодь галав хааны” судалгаа”²⁰ (吴胡日查, 2009), 2012 онд Бүтээлт, Хасбаатар нар “Монгол үндэстний Баатарын туулийн дуу хөгжмийн судлал”²¹ (Бүтээлт, Хасбаатар, 2012), 2021

¹⁸ Li jian Sin. (2020). Qorčin tuuli-iy qayilaqu čoyur jiči čoyurdaqu arу-a baril-un suduly-a Bürinčuylay-a čoyurči-yin qayiluysan “Asuru čayan qayičin” jīšiy-e-yin deger-e. [Хорчин туулийг хайлах цоор жич цоордох арга барилын судалгаа- Бүрэнцуглаа цоорчийн хайлсан “Асар цагаан хайчин” жишээн дээр] Kökeqota: Öbür Mongγol-un yeke surγayuli-yin magistriin jerge yorilaysan бүтүгел.

¹⁹ Nandinbilig, G. (2019). Qorčin-u yalба-un üliger deh domuy jüi-yin düri ügülemji. [Хорчины Галавын үлгэр дэх домог зүйн дүр өгүүлэмж] Tungliyao: Öbür Mongγol-un ündüsüten-u yeke surγayuli.

²⁰ Wu hu ri cha. (2009). Min jian yi ren Mu.Bu ren chao gu la de Bu di ga la ba ke han. [Ардын урлагч М.Бүрэнцуглаа хайлсан Бодь галав хаан] Hu he hao te: Nei meng gu shi fan da xue.

²¹ Bütügelte, Qasbayatur. (2012). Mongγol bayatur-un tuuli-ün dayu kögjim-ün sudulul. [Монгол баатарын туулийн дуу хөгжмийн судлал] Kökeqota: Dumdadu ulus-un neiyigem-ün sinjileku uqaygan-u keblel-ün qoriy-a.

онд Соргог “Хорчин тууль ‘Алтан галав хаан’ судалгаа”²² (苏日古, 2021), 2022 онд Ин Жэ “Жалсан хуурчийн хайлсан ‘Бодь галав хаан’ туулийн текст судлал”²³, Мандаахүү “Жалсан хуурчийн хэлсэн Галвын үлгэрийн судалгаа” (Мандаахүү, 2023). Эдгээрээс онцлон Бүтээлт, Хасбаатар нарын нэгэн сэдэвт судалгаа нь Бүрэнцуглаа хуурчийн хайлсан “Бодь галав хаан” туульд сууриж бүх монгол баатарлаг туулийн хөгжимд судалгаа хийсэн юм. Энэхүү бүтээл нь эрдэм шинжилгээний эрэл хэрэгцээнд нийцсэн, цаг үеийг заагласан, онолын хувьд ч өндөр төвшинд бичигдсэн судалгаа гэж үзэж болно. Эдгээр магистрын зэрэг горилж бичсэн судалгааны ажлын сэдэв чиглэлийг нэгтгэн үзэхэд Хорчинчуудын баатарлаг тууль хийгээд Мангасын үлгэр буюу Галавын үлгэрийн талаарх ерөнхийлсөн болон харьцуулсан судалгаа олон байх боловч тодорхой нэгэн туулийн дүр хийгээд өгүүлэмжийг нарийвчлан судлах замаар төрөл зүйлийн талаар онолын маргааныг шийдвэрлэсэн нь цөөн байлаа. Нэн ялангуяа Хорчинчуудийн дунд түгээмэл дэлгэрсэн “Бодь галав хаан” туулийн дүр, өгүүлэмжийг нарийвчлан судалж, чухам домог, туульс, үлгэрийн алин болохыг нэг сэдэвт зохиолын хэмжээнд тусгайлан судалсан судалгаа хараахан хийгдээгүй байна.

Дүгнэлт

Хорчинчуудын дунд “Галавын үлгэр”, “Мангасын үлгэр” хэмээх нэрээр уламжлан ирсэн монгол аман зохиолын нэгэн уламжлалыг төрөл зүйлийн хувьд чухам домог зүй болон баатарлаг туульсын алинд хамааруулах тухайд судлаачдын санал, онолын үзэл баримтлал маргаантай байна. Үүнд:

1. 1983 онд С.Дулам хорчины энэхүү аман уламжлалын жишээг судалгааны эргэлтэд оруулсан “Монгол домог зүйн бичвэр” бүтээлдээ “Галвын үлгэр” хэмээх ардын нэршлээр танилцуулсан ч төрөл зүйлийн хувьд домог зүй хэмээн үзсэн байна.

2. С.Ю. Неклюдов 1984 онд “Монголын баатарлаг тууль” номдоо тус бүтээлийн баатруудын нэг болох мангасын охин Галвин Сөөрийн дүрийг Гэсэрийн туужийн хорчин, жаруудын хувилбарын мангасын охин Гялбан шартай харьцуулан судалж, энэ хоёр бүтээл шууд холбоотой болохыг тодруулж, домог- тууль гэсэн нийлэг нэр томъёог хэрэглэсэн байна.

3. В.Хайссиг 1988 онд хожуу үеийн монголын баатарлаг туулийн хүүрнэлийн судалгааны тулгуур бүтээлдээ Галавын үлгэрийн тус бичвэрийг зүүн монголын туульсын хүрээнд авч үзэн, гүнзгий судалсан байна.

4. Мандахүү 2014 онд хэвлүүлсэн судалгааны түүвэр дэх Жалсан хуурчийн хэлсэн Мангасын үлгэрийн тухай өгүүлэлд “Эл төрлийн шидэт үлгэрийн агуулга нь арван найман Галавын үлгэрийг нөлөөлсөн бөгөөд Жалсан хуурчийн хайлсан арван найман Галавын үлгэр нь туулийн хэлбэртэй шидэт үлгэр болжээ гэсэн санааг дэвшүүлжээ.

5. 2019 онд Г.Нандинбилиг БНХАУ-ын Өвөр монголын өөртөө засах орны Жирэм аймгийн Тунляо хотод зохион байгуулагдсан “Хуурын үлгэр” сэдэв ОУЭШ-хуралд хэлэлцлүүлсэн Хорчины Галавын үлгэр дэх домог зүйн дүр өгүүлэмж гэх сэдэвт өгүүлэлд тус туулийн уламжлалт дүр,

²² Su ri gu. (2021). Ke er qin shi shi A la tan ga la ba ke han yan jiu. [Хорчин тууль Алтан галав хаан туулийн судалгаа] Hu he hao te: Nei meng gu shi fan da xue shuo shi xue wei lun wen.

²³ In je. (2022). jalsan ququrci-yin qayiluysan bodi yalba qayan tuuli-yin tekst sudulul. [Жалсан хуурчийн хайлсан Бодь галав хаан туулийн текст судлал] Tungliyao: Öbür Mongγol-un ündüsüten-u yeke surγayuli-yin erdem sinjilegen-u sedkül.

өгүүлэмжийн нарийвчлан судлаад, төрөл зүйлийн тухайд “Мангас махчны домог зүй” хэмээн тодорхойлж, ялгаатай саналыг дэвшүүлсэн байна.

6. Эдгээр олон янзын судалгааны санал дүгнэлтээс үндэслэн бид хорчинчуудын дунд түгээмэл дэлгэрсэн “Бодь галав хаан” хэмээх аман уламжлалын өвөрмөц хэлбэрийг цоорч Сэрэн, Бүрэнцугла, Жалсан нарын уламжлан дамжуулсан гурван зүйлийн ялгаатай хувилбарын баялаг жишээн дээр тулгуурлан задлан шинжилж, тус бүтээл нь төрөл зүйлийн хувьд чухам домог ба туульсын алинд хамаарахыг судлан тодорхойлох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Ном зүй

Монгол хэлээр:

- Bai Jin Süye. (2009.06). Sinjiyang Oyirad tuuli kiged qorčin tuuli daki mangγus-un düri-yin qaričayuluysan sudulul. [Шинжаан ойрад тууль хийгээд хорчин тууль дахь мангасын дүрийн харьцуулсан судлал] Kökeqota: Öbür Mongγol-un yeke surγayuli-yin magistriin jerge yorilaysan ögülel.
- Bütügelte, Qasbayatur. (2012). Mongγol bayatur-un tuuli-ün dayu kögjim-ün sudulul. [Монгол баатрын туулийн дуу хөгжмийн судлал] Kökeqota: Dumdadu ulus-un neiyigem-ün sinjileku uqaygan-u keblel-ün qoriy-a.
- Doronga. (1960). Bayaturliγ tuuli. [Баатарлаг тууль] Kökeqota: Öbür Mongγol-un arad-un keblel-ün qoriy-a.
- Дулам, С. (1982). Образы Монгольской мифологии и литературная традиция. УБ: МУИС-ийн хэвлэл.
- jü Süan Si. (2014.02). Qorčin tuuli-yin öbermiče sinji-yin tuqai ögülekü ni. [Хорчин туулийн өвөрмөц шинжийн тухай өгүүлэх нь] Kökeqota: Dumdadu ulus-un mongγol sudulul.
- In je. (2022). jalsan quγurči-yin qayiluysan bodi γalba qayan tuuli-yin tekst sudulul. [Жалсан хуурчийн хайлсан Бодь галав хаан туулийн текст судлал] Tungliyao: Öbür Mongγol-un ündüsüten-u yeke surγayuli-yin erdem sinjilegen-u sedkül.
- Kürelša. (2013). Qorčin arad-un aman jokiya sudulul. [Хорчин ардын аман зохиол судлал] Kökeqota: Öbür Mongγol-un arad-un keblel-ün qoriy-a.
- Li jan Sing. (2020). Qorčin tuuli-iy qayilaqu čoyur jiči čoyurdaqu arγ-a baril-un sudulγ-a Bürinčuγlay-a čoyurči-yin qayiluysan “Asuru čayan qayičin” jisiy-e-yin deger-e. [Хорчин туулийг хайлах цоор жич цоордох арга барилын судалгаа- Бүрэнцуглаа цоорчийн хайлсан “Асар цагаан хайчин” жишээн дээр] Kökeqota: Öbür Mongγol-un yeke surγayuli-yin magistriin jerge yorilaysan bütügel.
- Li Meyi. (2013). jang üile-iin qarayana-ača qorčin tuuli-iy sinjilekü ni. [Зан үйлийн хараанаас хорчин туулийг шинжлэх нь] Kökeqota: Öbür Mongγol-un bayči-yin yeke surγayuli-yin magistriin jerge yorilaysan ögülel.
- Manduqu. (2014). Mandaqu jokiya sudulul. [Мандах зохиолын түүвэр] nigedüger boti, arad-un aman jokiya sudulul. Kökeqota: Öbür Mongγol-un arad soyul-un keblel-ün qoriy-a.
- Mongγol ündüsüten-ü udq-a jokiya sudulul. [Монгол үндэстний утга зохиолын материалын эмхэтгэл, гуравдугаар дэвтэр] Kökeqota: Öbür Mongγol-un kele jokiya sudulul γajar.
- Nandinbilig, G. (2019). Qorčin-u γalba-un üliγer deh domuy jüi-yin düri ügülemji. [Хорчины Галавын үлгэр дэх домог зүйн дүр өгүүлэмж] Tungliyao: Öbür Mongγol-un ündüsüten-u yeke surγayuli.
- Nim-a. (1988). jегün mongγol-un mangγus-un üliγer-ün tuqai. [Зүүн монголын мангасын үлгэрийн тухай] Kökeqota: Öbür Mongγol-un bayči-ün yeke surγayuli-yin erdem sinjilegen-u sedkül.
- Uryumal. (2017.06). Pazai Geser kiged qorčin mangγus-un üliγer-ün düri-ün qaričayulul. [Пазэй Гэсэр хийгээд хорчин мангасын үлгэрийн дүрийн харьцуулал] Čing Qai: Barayun qoid ündüsüten-u yeke surγayuli-yin magistriin jerge yorilaysan ögülel.

- Tegüs, F. (1979). Asar čaγan qayıčın. [Асар цагаан хайчин] Kökeqota: Öbür Mongγol-un arad-un keblel-ün qoriy-a.
- Sawanpilnorbu., Čoyiǰikawa & Čimbey, T. (1990). Bodi γalba qayan. [Бодь галав хаан] Kökeqota: Ündüsüten-ü keblel-ün qoriy-a.
- Qaissig, W., Feyt, F & Nim-a. (1988). Altan γalba qayan. [Алтан галав хаан] Kökeqota: Öbür Mongγol-un arad-un keblel-ün qoriy-a.
- Čandan. (2012.02). Qorčın tuuli daki mangγus kiged aman üliger dek mangγus-un qaričayulul. [Хорчин тууль дахь мангас хийгээд аман үлгэр дэх мангасын харьцуулал] Tungliyao: Öbür Mongγol-un ündüsüten-u yeke surγayuli-yin erdem sinǰilegen-u sedkül.
- Čenggel. (2021). Qorčın čoyur tuuli. Degedü. [Хорчин цоор тууль. дээд] Kökeqota: Öbür Mongγol-un yeke surγayuli-yin keblel-ün qoriy-a.
- Sen Gan Lün. (2003). Mangγus-un üliger-ün onul. [Мангасын үлгэрийн онол] Begeǰing: Begeǰing-ün bayči-yin yeke surγayuli-yin keblel-ün qoriy-a.
- Šügara, Ü. (1985). Pajayi-yi ögülekü ni. [Пажэйг өгүүлэх нь] Kökeqota: Öbür Mongγol-un arad-un keblel-ün qoriy-a.

Гадаад хэлээр:

- Zhao r ige tu. (2008.03). Ke er qin meng gu zu shuo chang yi shu – hu ren wu li ge er wu xu shi min ge bi jiao. [Хорчин монголчуудын хайлах урлаг - хуурын үлгэр дэх хүүрнэл бус ардын дууны харьцуулалт] Tian jin: Tian jinshi fan da xue yan jiu sheng xue wei lun wen.
- Wu hu ri cha. (2009). Min jian yi ren Mu.Bu ren chao gu la de Bu di ga la ba ke han. [Ардын урлагч М.Бүрэнцуглаа хайлсан Бодь галав хаан] Hu he hao te: Nei meng gu shi fan da xue.
- Su ri gu. (2021). Ke er qin shi shi A la tan ga la ba ke han yan jiu. [Хорчин тууль Алтан галав хаан туулийн судалгаа] Hu he hao te: Nei meng gu shi fan da xue shuo shi xue wei lun wen.

Abstract

The horqin region is the centre of Mongolian Epics. Among the numerous epics to be found in the horqin region, there are twenty-four (eighteen main chapters and six sub-epics), sagas that are very unique in form and content. The first Chapter of this eighteen-chapter series will be the epic Bodhi Galab Khan. The epic poem “Bodhi Galab Khan” is called the First Galab or the First Galab by the horqin Mongolians. It is thought that after this first Galab, 18 more gala periods followed. The name of these periods include the second “Altan Galab Khan”, the third “King of Ultimate Heroes”, the fourth “Knig of the Golden Stone”, the seventeenth “Imaginary Heroes”, and the seventeenth “The King of the Golden Stone”. “The Hero of Dreams”, the 18th “The Blue Bull”. It will be Horqin people call these legends and epics “eighteen stories” or “eighteen strange stories”. The first two legends, “Bodhi Galab Khan” and “Altan Galab Khan”, are epic stories because they relate the origin of the world of Galab. In the epic poem “Bodhi Galab Khan”, “Bodhi Galab Khan” along with the stone forest, fights against the horned monster with the mad hero and extols the heroics of the final victory over the monster. In this paper, we are presenting for the first time how scholars at home and abroad have collated and analysed the epic “Bodhi Galab Khan” and how they have come to divergent conclusions.